

БАТЛАВ
БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА.....Э.БАТТУЛГА

2023 оны 12 дүгээр сарын 30

**“БУЙР НУУР-ХАЛХ ГОЛЫН САВ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛАН
ШИНЭЧЛЭХ/ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛАХ” ЗӨВЛӨХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР**

Зөвлөх үйлчилгээний дугаар: Төслийн 2023 оны ажлын төлөвлөгөөний 1.2.2 дахь ажил

1. Үндэслэл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хүрээнд байгуулагдсан Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилттэй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөл 2021 оны 7-р сараас эхлэн хэрэгжиж байна. Энэхүү төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн газар хамтран 7 жилийн хугацаанд Дорнод, Сүхбаатар, Завхан, Ховд аймагт хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжсэнээр ойролцоогоор 130,000 гаруй малчин иргэд шууд, 800,000 орчим иргэд шууд бусаар төслийн үр шим хүртэхээс гадна тэдгээрийн 50 хувь нь эмэгтэйчүүд байна. Төслийн зорилго нь байгалийн нөөцөөс хамааралтай, уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий малчдын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлийг даван туулах чадамжийг сайжруулан бэхжүүлэх юм. Тус зорилгод хүрэхийн тулд хоорондоо уялдаатай дараах бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэн үр дүнд хүрэх болно. Үүнд:

- Бүрэлдэхүүн хэсэг 1: Үндэсний болон бүс нутгийн түвшинд газар, усны нөөцийн төлөвлөлтийг уур амьсгалын мэдээлэлд тулгуурлан төлөвлөж, ашигладаг болох;
- Бүрэлдэхүүн хэсэг 2: Байгалийн нөөцийн менежментэд малчдын оролцоог нэмэгдүүлж уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон ус, хөрсний менежментийн арга ажиллагааг өргөн хүрээнд нэвтрүүлэх;
- Бүрэлдэхүүн хэсэг 3: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, гарал үүсэл нь тогтвортой малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх малчдын чадавхыг нэмэгдүүлэх зэрэг болно.

2. Зорилго

Энэхүү зөвлөх үйлчилгээний зорилго нь **Буйр нуур-Халх голын сав газрын УННМТ-ний хэрэгжилтийг үнэлэх, Буйр нуур-Халх голын сав газрын экосистем, усны нөөцөд уур амьсгалын өөрчлөлтөөс үзүүлж болзошгүй нөлөөллийг Сав газрын захиргаатай хамтран тодорхойлж, усны нөөцийн хамгаалал болон ашиглалтын арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн (ойрын 5,10 жил) хандлага, эрсдэлтэй уялдуулан дүн шинжилгээ хийж, дасан зохицох арга хэмжээ бүхий УННМТ-г шинээр боловсруулж, батлуулахад оршино. Мөн сав газрын УННМТ-г сав газрын мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулах замаар уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл эмзэг байдалд дасан зохицох арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх нь энэхүү зөвлөх үйлчилгээний зорилгод багтана.**

3. Зөвлөх үйлчилгээний техникийн тодорхойлолт

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаанд үндэслэсэн сав газрын УННМТ-г шинээр боловсруулах, дасан зохицох арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн судалгааг сав газрын хэмжээнд хийх, түүнд суурилсан УННМТ-г шинээр аргачлалын дагуу боловсруулах, экосистемд суурилсан дасан зохицох арга хэмжээний төлөвлөлтийг хийх бүхий л үе шатуудад холбогдох сав газрын мэргэжилтнүүдийг оролцуулж, хамтран судалгааг хийж гүйцэтгэх замаар сав газрын захиргааны мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах.
2. Уур амьсгалын өөрчлөлтөөс усны нөөц, сав газарт үзүүлж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, дасан зохицох онцлогийг тусган, нэгтгэн шинэчлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулах, боловсруулж дүн шинжилгээ хийх. Үүнд:
 - Үндэсний бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан үндэсний хэмжээнд дасан зохицох арга хэмжээнүүдийг судалж, уялдуулах: Алсын хараа-2050, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын УННМТ, Байгаль орчны Зорилтот хөтөлбөр, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогын баримт бичиг, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Байгаль орчны төлөв байдлын тайлан, статистикийн мэдээ гэх мэт;
 - Аймгийн хөгжлийн төлөвлөлт, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн чиглэл, төлөвлөгөө;
 - Буйр нуурын ёроолын хэмжилт, усны баланс, биологийн олон янз байдал, эргийн экосистемийн өөрчлөлтийн судалгааны ажлыг гүйцэтгэж буй төслийн зөвлөх багтай нягт хамтран ажиллана.
 - Эрсдэл, эмзэг байдалтай уялдуулсан Улс, аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах шинэчилсэн аргазүй, аргачлал, зарим сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлт гэх мэт ажлыг гүйцэтгэж буй төслийн бусад зөвлөх багуудтай нягт хамтран ажиллаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг солилцох, газрын төлөвлөгөөнд усны нөөцийг зохистой ашиглах болон усны нөөцийг хамгаалах, дасан зохицох үйл ажиллагааны байршлыг тусгах, гарсан зөвлөмж чиглэлтэй уялдуулах.
3. Буйр нуур-Халх голын сав газрын УННМТ-ний хэрэгжилтийг үнэлж, уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдлын судалгаа, дасан зохицох арга хэмжээ бүхий УННМТ-г сав газрын захиргаатай хамтран шинээр боловсруулж, батлуулах.
 - Сав газрын УННМТ-ний хэрэгжилтийг үнэлж, дүн шинжилгээ хийх, хил дамнасан усны зохицуулалттай холбоотой хийх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох;
 - Сав газрын усны нөөцийн ашиглалтын балансыг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, одоогийн ус хэрэглээ, ашиглалтын байдалтай уялдуулан сав газрын хэмжээнд бүхэлд нь болон дэд сав газраар тооцох;
 - Сав газрын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөллийг загварчлан гаргах, нөлөөллийн эрчмийг дэд сав газруудаар тодорхойлох, сааруулах арга замыг тусгах, шаардлагатай үйл ажиллагааг байршлаар тодорхойлох;
 - Уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас доройтолд орж буй болон болзошгүй газруудын байршлыг үйл ажиллагааны төрөл бүрээр сав газрын хэмжээнд зураглаж, дасан зохицох арга хэмжээг санал болгох;
 - Усны нөөцийн ашиглалтын хэтийн төлөвийг тухайн аймаг сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлттэй харьцуулан үнэлэх, мал аж ахуйн салбарын усны эрэлтийг тооцохдоо бэлчээрийн даац, ус хангамжийн нөхцөлийг харгалзан үзэх, бэлчээрийн талхагдал, цөлжилт, усны нөөцийн хомсдол зэрэг сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг дасан зохицох арга хэмжээтэй уялдуулан тодорхойлох;
 - Халхгол сум нь газар тариалан хөгжих боломжтой бүс нутаг тул усалгаатай газар тариалан цаашид хөгжих боломжийг судлах;
 - Гадаргын усны ашиглалтыг нэмэгдүүлж өрхийн амьжиргааг дэмжсэн арга хэмжээг төлөвлөх;
 - Уул уурхайн ус ашиглалт, хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох;
 - Буйр нуур түүний эрэг орчмын ус намгархаг газрын шувуудын нарийвчилсан судалгаанд үндэслэн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг харгалзан хамгааллын арга хэмжээг төлөвлөх;
 - Буйр нуурын загасны судалгаа, загас агнуур болон УАӨ-ийн нөлөөллийг судалж, хамгаалах арга хэмжээг төлөвлөх;
 - Сав газрын УННМТ-нд нийгэм, эдийн засаг, томоохон болон голлох ус ашиглагчид, тухайн нутгийн иргэдийн жендерийн болон залуусын тэгш оролцоог хангах

- Сав газрын УННМТ-нд нийгэм, эдийн засаг, томоохон болон голлох ус ашиглагчид, тухайн нутгийн иргэдийн жендерийн болон залуусын тэгш оролцоог хангах чиглэлийн асуудлуудыг тооцоолох, үүрэг хариуцлагыг тодорхой болгож, зөвлөмж боловсруулах;
 - Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөгөөнд ус, хөрсний хамгаалал, байгалийн нөөцийн менежментийн нэн шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх газар нутгийн сонголтыг дээрх судалгааны үр дүнд үндэслэн сав газрын захиргаатай хамтран сав газрын хэмжээнд тодорхойлох;
 - Дээрх судалгаанд үндэслэн дасан зохицох арга хэмжээ болох усны нөөцийг хамгаалах, голын татмыг нөхөн сэргээх шаардлагатай газрууд (доройтлын шалтгааныг үндэслэн)-ыг тодорхойлох, хөв цөөрөм барих гадаргын усны ашиглалтыг нэмэгдүүлэх хуримтлуулах байгууламжийг боломжит байршлыг тодорхойлох, булаг шандыг хамгаалах газруудыг тодорхойлж, түүнийг хариуцан хамгаалах менежментийг боловсронгуй болгох оновчтой санал оруулах;
 - Сав газарт малын тоо толгойн өсөлт, сүргийн бүтцэд усны нөөцийн одоо болон ирээдүйн хүртээмж, баланс, ашиглалт, бэлчээрийн даацтай холбон дүн шинжилгээ хийж, малын ус хэрэглээний хэтийн төлөвийг нарийвчлан тооцох. Улмаар малын ус хангамжийг нэмэгдүүлэх уст цэгийг байгуулах боломжит байршлыг зураглан гаргах;
 - “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд шаардлагатай усны нөөцийн эрэлт хэрэгцээг тооцох, шийдвэрлэх арга замыг саарал усыг эргүүлэн ашиглах, экосистемд суурилсан арга технологиор шийдвэрлэх шийдлийг санал болгох;
 - Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн менежмент, дасан зохицох онцлогийг тусгахтай холбоотой санал, шийдэл, боломжит хувилбарууд, зөвлөмжүүдийг төсөл хэрэгжүүлэгч нэгж болон тухайн нутгийн иргэд, төслийн холбогдох оролцогч талууд, Талуудын оролцооны зөвлөлд танилцуулах, гарсан санал, зөвлөмжийг тайланд нэгтгэн тусгах;
 - Батлагдсан УННМТ-г 300-с доошгүй хувь хэвлэж, сав газрын оролцогч талуудад хүргүүлэх;
 - Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа мэдээлэлд үндэслэн сав газрын усны нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт шинжилгээ, мониторинг хийхэд нь Буйр нуур-Халх голын сав газрын захиргаанд дэмжлэг үзүүлэх. Үүнд: СГЗ-нд нийт төсөвт өртгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний төсвөөр мониторингийн багаж худалдан авч өгнө.
4. Уур амьсгалын өөрчлөлтөөс усны нөөцөд үзүүлж буй нөлөөллийн судалгаанд үндэслэн экосистемд суурилсан дасан зохицох арга хэмжээг төлөвлөн, байгальд ээлтэй шийдлийг гаргасан, зүүн бүсийн экосистемд тохиромжтой байдлаар тэдгээрийг хэрэгжүүлэх техникийн тодорхойлолт, сөрөг нөлөөллөөс хамгаалах, барьж байгуулах аргачлалыг боловсруулах. Үүнд:
- Барьж байгуулах шаардлагатай жижиг оврын “Ардын” хөв;
 - Хашиж хамгаалах шаардлагатай булаг шанд;
 - Татмын ойн нөхөн сэргээлт буюу ойжуулах шаардлагатай татмын нуур, голын татам;
 - Бэлчээрийн зохистой менежменттэй холбоотой уст цэгийг нэмэгдүүлэх гэх зэрэг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжит байршлыг Дорнод аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд дэд сав газраар тодорхойлж, зүүн бүсийн экосистемд тохиромжтой байдлаар тэдгээрийг хэрэгжүүлэх техникийн тодорхойлолт, аргачлалыг боловсруулах;
 - Техникийн тодорхойлолт, аргачлалд дасан зохицох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай газрын байршил, зургийг баримтжуулан оруулж, арга хэмжээг төлөвлөх шаардлагыг тодорхойлж, ямар үр дүнд хүрэх талаар төсөөллийг оруулна.
 - Төлөвлөгөөг хэрэгжүүлэх заавар чиглэлийг хамтад нь гаргах, сав газрын захиргаа орон нутгийн удирдлагад мэдээлэх
 - Дээрх нарийвчлан гаргасан дасан зохицох арга хэмжээний байршлыг холбогдох аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд уялдуулан тусгах.
- 5. Хүрэх үр дүн**

Үр дүн 1. Байгалийн нөөцийн менежментийн арга хэмжээ (Төслийн Бүрэлдэхүүн 2-ын хүрээнд гүйцэтгэх ажлууд болох булгийн эхийг хамгаалах, татмын ойжуулалт, хөв цөөрөм

байгуулах, бэлчээрийн зохион байгуулалт, усны эх үүсвэр, худаг, уст цэг гаргах, ашиглах нөхцлийг сайжруулах гэх мэт)-ийг хэрэгжүүлэх шаардлага, газар нутгийн сонголтыг Дорнод аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тодорхойлж, тухайн сав газар дахь экосистемийн онцлогт тохирсон байдлаар хэрэгжүүлэх техникийн тодорхойлолт, аргачлалыг боловсруулна.

Үр дүн 2. БОАЖС-ын 2020 оны А/42 тушаалаар батлагдсан Сав газрын менежментийн төлөвлөгөөний аргачилсан зааврын дагуу Буйр нуур-Халх голын сав газрын УННМТ-ний хэрэгжилтийн үнэлгээг гаргаж, 2022-2030 онд хэрэгжүүлэх УННМТ-г уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги, эрсдэлийн менежменттэй уялдуулан шинээр боловсруулж батлуулсан байна.

Үр дүн 3. Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаанд үндэслэн усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг тооцож, дасан зохицох төлөвлөлт хийх чадавхыг Сав газрын захиргаанд бүрдүүлсэн байна. Буйр нуур-Халх голын СГЗ-нд нийт төсөвт өртгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний төсвөөр мониторингийн багаж худалдан авч өгнө.

6. Бүтээгдэхүүн

Зөвлөх баг нь дараах бүтээгдэхүүнийг захиалагч талд хүлээлгэн өгнө. Үүнд:

Бүтээгдэхүүн 1: Эхлэлийн тайлан

- Ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө, ажлын явцад хийгдэх үйл ажиллагааны хуваарь, эхлүүлсэн ажлын талаар тойм гаргаж төсөл хэрэгжүүлэх нэгжид танилцуулах, тайлагнана;
- Сав газарт одоо хэрэгжиж буй УННМТ-нд уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдал, дасан зохицох арга хэмжээг төлөвлөсөн эсэхэд дүн шинжилгээ хийж, сав газрын УННМТ-нд уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдлыг тооцон уялдуулах аргачлалыг танилцуулна;
- Эрсдэлийг даван туулах, дасан зохицох онцлогуудтай уялдуулах арга аргачлал, төлөвлөгөөг танилцуулна.

Бүтээгдэхүүн 2: Явцын тайлан (санхүүжүүлэгч талын загвараар)

Бүтээгдэхүүн 3: Буйр нуур-Халх голын сав газарт Дорнод аймгийн нутаг дэвсгэрт хамаарах хэсэгт төслийн хүрээнд хэрэгжүүлэх дасан зохицох арга хэмжээний байршлыг тогтоож, аргачлалыг санал болгосон тайлан.

Бүтээгдэхүүн 4: Буйр нуур-Халх голын сав газрын УННМТ-ний төсөл. Үүнд:

- УННМТ-нд уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн менежмент, дасан зохицох онцлог, жендерийн чиглэлээр орхигдуулсан асуудлыг тусгаж нэмэлт өөрчлөлт оруулах санал;
- Газарзүйн мэдээллийн систем (GIS) ашиглан тухайн сав газруудын онцлогийг харуулсан сэдэвчилсэн зургууд (файлаар) ;
- Дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөлт, орон нутгийн байгууллага, нутгийн иргэдийн үүрэг оролцоог тодорхой болгох.

Бүтээгдэхүүн 5: Ажлын үр дүнг холбогдох талуудад танилцуулах хэлэлцүүлэг, хурал зохион байгуулах болон хурлын тэмдэглэл (жендерийн тэгш оролцоог хангах үүднээс оролцогчдын бүртгэлийг хүйсээр ангилсан байх, оролцооны зарчмыг баримтлах)

Бүтээгдэхүүн 6: Тайлан-илтгэлийн товч хураангуй сав газар бүрээр

Бүтээгдэхүүн 7: Зөвлөх багийн ажлын хүрээнд хийгдсэн тооцоо, судалгааны анхдагч болон суурь мэдээллүүд, түүний тайлбар томьёог (цаасан болон файл хэлбэрээр),

Бүтээгдэхүүн 8: Зөвлөх үйлчилгээний ажлыг хүрээнд хийж гүйцэтгэсэн бүхий л ажлын дэлгэрэнгүй тайлан, тайлангийн товч хураангуй болон танилцуулгууд. Нэгдсэн тайлан нь англи, монгол хэл дээр байна.

7. Ажил гүйцэтгэх хугацаа

Ажил гүйцэтгэгч нь гэрээ байгуулагдсан өдрөөс хойш нийт есөн (9) сарын хугацаанд багтаан тус ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд УННМТ-ний төслийг хэлэлцүүлэх, батлуулах хугацаа ороогүй болно.

8. Санхүүжилт

Тус гэрээт ажлыг гүйцэтгэгчийн ажлын хөлсний нийт төсөвт өртөг нь **100,000,000** (Нэг зуун сая) төгрөг байх ба төсөвт өртгийн 20 хувийг Буйр нуур-Халх голын сав газрын захиргааг чадавжуулахад зарцуулна.

9. Төлбөрийн нөхцөл

Дараах төлбөрийн нөхцөлийг баримтална. Үүнд:

- Эхний төлбөр болох 30%-г талууд гэрээг гарын үсгээр албажуулж, ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг хүргүүлсэн нөхцөлд хийнэ.
- Дараагийн төлбөр болох 30%-ийг явцын тайлан болон Бүтээгдэхүүн 3-ыг ирүүлсэн нөхцөлд хийнэ.
- Үлдэгдэл төлбөр болох 40%-ийг Бүтээгдэхүүн 4-8 дахь хэсэгт заагдсан хүрэх үр дүн, эцсийн тайланг хүлээлгэн өгч Зөвлөх үйлчилгээг эцэслэн дүгнэсний дараа хийнэ.

Нийт төсөвт өртөгт ажил гүйцэтгэгч багийн гишүүдийн ажлын хөлс, орон нутагт ажиллах томилолтын зардал, төлөвлөгөөний төслийг холбогдох талуудад танилцуулж, хэлэлцүүлэх зардал, батлагдсан сав газрын төлөвлөгөөг 300 хувь хэвлүүлэх зардал болон Сав газрын захиргааг чадавжуулах зардал багтсан болно.

Ажил гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлтийн газар болон “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн хэрэгжүүлэх нэгжийн мэргэжил, арга зүйн зөвлөмж, шийдвэрийг удирдлага болгоно.
- Сав газрын УННМТ-г БОАЖС-ын 2020 оны А/42 тоот тушаалаар батлагдсан аргачилсан заавар, төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хэлэлцэж тохирсон Сав газруудын УННМТ-г уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдлыг даван туулах, дасан зохицох онцлогуудтай уялдуулах арга аргачлалын дагуу боловсруулна.
- Төслийн санхүүжүүлэгч байгууллага болох Уур амьсгалын ногоон сангийн Байгаль орчин, нийгмийн бодлого (GCF Environmental and Social Policy) болон хэрэгжүүлэгч Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн Нийгэм, байгаль орчны стандарт (UNDP Social and Environmental Standards 2021)-д заасан шаардлагын дагуу ажиллаж, зөвлөх үйлчилгээг гүйцэтгэнэ.
- Энэ ажлын хүрээнд бүрдүүлсэн бүх мэдээлэл нь зөвхөн энэхүү Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын гүйцэтгэлд ашиглагдах бөгөөд ажлын даалгаврыг хэрэгжүүлэхтэй холбоотой оюуны өмчийн бүх эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжүүлнэ.
- Энэхүү даалгаврыг гүйцэтгэхэд ашигласан мэдээлэл, материал, холбогдох баримт бичгийг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд нээлттэй өгөхийг хориглоно.
- Тус ажилд холбогдох талууд, олон улсын төсөл хөтөлбөрийн нэгжүүдийн харилцан уялдааг хангаж ажиллах зэрэг болно.

10. Зөвлөх багт тавигдах шаардлага

Энэ зөвлөх үйлчилгээний ажлыг байгаль орчин, усны салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд болон иргэн, хуулийн этгээдтэй хамтран түншлэл хэлбэрээр оролцон гүйцэтгэж болно. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь 8-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд багийн гишүүд усны нөөцийн нэгдсэн менежмент, уур амьсгалын өөрчлөлт, МАА-н ус хангамжийн чиглэлээр 5-аас дээш жил ажилласан, бодлогын баримт бичгийг боловсруулах ажилд оролцож байсан туршлагатай байна. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх баг нь дараах шаардлага хангасан байна. Үүнд:

Зөвлөх багийн ахлагч

Байгаль орчин, усны чиглэлээр мэргэжил эзэмшсэн байх, уур амьсгалын өөрчлөлт, усны нөөцийн судалгаа, сав газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах гэх мэт чиглэлээр судалгаа хийж байсан туршлагатай байна. Эрдмийн зэрэгтэй бол давуу тал болно.

Багийн гишүүд

- Усны инженер (мэргэжил давхцахгүй гидрологи, гидрогеологи, гидротехникийн инженерийн аль нэгийг) эзэмшсэн, магистр ба түүнээс дээш зэрэгтэй 2 зөвлөх;
- Цаг уурч, уур амьсгалын чиглэлээр магистр эсвэл түүнтэй адилтгах 1 зөвлөх;
- Хөрс судлал, газарзүй, биологийн чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй 1 зөвлөх;
- Ой судлал, экологи, ойн инженерийн чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй 1 зөвлөх;
- Социологи, нийгмийн шинжлэх ухаан, нийгэм судлал, олон нийтийн бодлогын чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй 1 зөвлөх;
- ХАА/МАА-н бодлого, төлөвлөлтийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, магистр ба түүнээс дээш зэрэг хамгаалсан 1-2 зөвлөх.

ХЯНАСАН

БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлтийн газрын дарга, Төслийн захирал

Ш. Цэрэндулам

НҮБХХ-ийн Хөтөлбөрийн шинжээч

Х.Хишигжаргал

Төслийн зохицуулагч

Ю.Баяржаргал

БОЛОВСРУУЛСАН



Төслийн уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон төлөвлөлтийн техникийн мэргэжилтэн



Б.Саранцэцэг

АЖЛЫН ДААЛГАВРЫН ХАВСРАЛТ

Багц 3. Буйр нуур-Халх голын сав газрын менежментийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан шинэчлэх/шинэчлэн боловсруулж батлуулах” зөвлөх үйлчилгээ

Төсөвт өртгийн 20 хувиар (20 сая орчим) Буйр нуур, Халх голын СГЗ-нд дараах багажийг худалдан авч өгнө. Үүнд:

Д/д	Багажийн нэр	Хүлээлгэн өгөх байгууллага	Техникийн тодорхойлолт	Зах зээлийн үнэ, төг	Загвар жишээ	Хэрэгцээ шаардлага, хүрэх үр дүн
1	Дрон / DJI Mavic 3 Fly More Combo/	Буйр нуур, Халх голын СГЗ	Овор хэмжээ 180×86×10 mm, ажиллах цаг 6 цаг, Зураглах хугацаа 50 минут, туулах зай 30 км, салхины хурд 12 м/сек хүртэлх нөхцөлд ажиллах, авсан зургийн форматууд- JPEG/DNG (RAW)	8 сая төг		-Нуурын талбайн хэмжээг гаргах; -Машинаар хүрэх боломжгүй уст цэгийн мэдээллийг бүрдүүлэхэд ашиглана.
2	Усны түвшин хэмжигч Insitu бренд		100 м дамарны урттай 36 см өргөн, 31 см өндөр 2,3-4,1 кг Статик болон drawdown 9V alkaline Усанд зэвэрдэггүй ган Бат бөх полиуретана ар бүрсэн ган карказан дээр суурилсан	4,7 сая төг		-Худаг, цооногийн статик, динамик түвшин хэмжих; -Газрын доорх усны мэдээллийн дэд санг бүрдүүлнэ.

			600м хүртэл урттай Миллметр бүрийн нарийвчлалтай			
3	RUIDE RAL-4 Автомат нивелир		Стандарт 1 км-ийн хазайлт-1.0 мм -Зураг босоо -Олон тогмтол 100 -Нэмэх тогтмол 0 Компресаторын -төрөл-соронзон чиглүүлэгч -Нөхөн төлбөрийн нарийвчлал-0,4 -Нөхөн олговорын -хүрээ+15 -Тойрог төгсөлт 360° 400 гон Хамгаалалтын анги IP54	660,000 төг		-Гол, нуурын харуулыг түшиглээд усны түвшин, харуулын чиглэлийн голын гольдролыг тодорхойлох, мэдээллийн санг бүрдүүлэхэд ашиглана.
4	Зургийн аппарат	Буйр нуур, Халх голын СГЗ	/CANON EOS R10 MIRRORLES S, 18-150MM STM, DIGIC X, APPROX. 24.2MP APS-C CMOS/	5,9 сая төг		Усны тоо бүртгэл зохион байгуулах, хээрийн ажил, хяналт шалгалт хийх, мэдээллийн сан бүрдүүлэхэд чанартай зургийн аппарат шаардлагатай байдаг.
	Нийт төсөв			19,36 сая төг		

НЭГТГЭСЭН

Төслийн уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон төлөвлөлтийн техникийн мэргэжилтэн



Б.Саранцэцэг